

БНЧех Улсын Гаалийн албаны эрх мэдэл

БНЧех улсын Гаалийн алба нь захиргааны байгууллага болохоос гадна улсыг аюулаас хамгаалах хүчний үүрэг гүйцэтгэдэг. Европын гаалийн холбооны нэгдсэн нутаг дэвсгэрт бараа таваарт тавих гаалийн хяналтын тогтолцооны хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, Холбооны гаалийн дүрэм журмыг баримталж ажиллаж байна. Эдгээр журамд Холбооны гаалийн журам болоод түүнийг гүйцэтгэх тогтоолууд, импортын гаалийн татвараас чөлөөлөх тогтолцоо, Холбооны гаалийн нэгдсэн тариф зэрэг тогтоомж орно. Тус улсын Гаалийн албаны зарим ангиуд нь эрүүгийн зарим гэмт хэрэг илрүүлэх ажиллагаанд цагдаагийн байгууллагатай ижил эрх эдлэдэг.

Гаалийн ажиллагаа ба гаалийн асуудал эрхлэх ажилд дараахь асуудал хамаарна. Жишээлбэл,

- импортлох, экспортлох, дамжин өнгөрөөх бараа бүтээгдэхүүнд гаалийн хяналт тавих;
- бараа бүтээгдэхүүний төрөл ангилалыг гаалийн тухай хуультай нийцүүлэн тогтоох, гаалийн өр авлагыг барагдуулах, гаалийн үнэ тогтоох асуудлаар шийдвэр гаргах;
- БНЧУ, ЕХ-ны худалдаа-улс төрийн арга хэмжээг болон импорт, экспорт, бараа дамжин өнгөөрөөхөд тавьсан хориг, хязгаарыг баримтлуулах; гаалийн дүрэм журмын зөрчлийн талаарх ажиллагаа явуулах, үүнтэй холбоо бүхий чухал бараа бүтээгдэхүүнийг битүүмжлэх, хураан авах;
- Хууль бусаар оруулсан, гаргасан эсвэл гаалийн хяналтаас зайлсхийсэн барааг илрүүлэх, түүнчлэн тус үйлдэл үйлдсэн, оролцсон эсвэл барааг авсан этгээдийг илрүүлэх.

Хэрэглээний болон эрчим хүчний татварын асуудал эрхлэх – хэрэглээний татвартай холбоо бүхий бүх асуудал эрхлэх, түлш шатахууны борлуулагчдын бүртгэл хөтлөх, газрын болоод өөр бусад зарим хий, хатуу түлш, цахилгаанаас авах татвартай холбоотой асуудлыг шийдвэрлэдх.

Татвартай холбоотой хуваарилагдсан үүрэгт ажиллагаа – захиргааны ажиллагааны тухай хуулийн дагуу төрийн бусад байгууллагаас ногдуулсан, улсын төсөв, улсын сан эсвэл орон нутгийн төсвийн орлого болох торгууль зэрэг авлагыг төлүүлэх.

Бэлэн төлбөр тооцоог хязгаарлахад хяналт тавих – хөрвүүлэхэд 15 мянган ЕВРО-гоос дээш үнэ бүхий төлбөр тооцоог банкны шилжүүлгээр хийх дүрмийн гүйцэтгэлд хяналт тавих.

Улсын хилээр мөнгө, үнэт зүйлсийг нэвтрүүлэхдээ иргэдийн мэдээлэх үүргийн биелэлтэд хяналт тавих – хөрвүүлэхэд 10 мянган ЕВРО-гоос дээш үнэ бүхий мөнгө, алт, алмаз зэрэг үнэт зүйлсийг улсын хилээр нэвтрүүлэх явдалд хяналт тавих.

Оюуны өмчийг хамгаалах – оюуны өмчийн эрх зөрчиж болзошгүй бараа бүтээгдэхүүныг тус улс дахь эргэлтэд хяналт тавих.

Байгаль хамгаалах - улсын хилээр ургамал, амьтан оруулах, гаргах, оруулж гаргах, дамжин өнгөрүүлэх тохиолдолд CITES (Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora)-аар хамгаалагдсан эсэхийг шалгах.

Түүх, соёлын үнэт зүйлсийг хамгаалах – түүх, соёлын үнэт зүйлсийг тээвэрлэхэд БНЧУ-аас гаргах зөвшөөрөл зэрэг шаардлагатай бүх баримт бичиг буй эсэхийг шалгах.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисыг тээвэрлэхэд хяналт тавих – өөрөөр хэлбэл, хар тамхи, анаболик зэргийг тээвэрлэхэд хяналт тавих.

Зам тээврийн салбарт хяналт тавих – үүнд ялангуяа ачааны автомашины жин хэмжих, хурдны зам ашиглалтын төлбөрийн бүх хэлбэрт хяналт тавих, аюултай ачаа тээвэрлэхэд тавьсан шаардлагын биелэлтэд хяналт тавих.

Гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд хяналт тавих – ажил олгогчид ЕХ-ны иргэд, гуравдагч орны иргэдийг хөдөлмөр эрхлүүлэхдээ хуулиар заасан үүргээ биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа – гаалийн байгууллага нь хууль хяналтын байгууллагын хувьд гааль, татварын тухай хууль тогтоомжийг зөрчснөөс үүссэн гэмт хэрэгтэй холбоотой байцаан шийтгэх ажиллагаанд оролцдог.

БНЧех Улсын Гаалийн байгууллага нь дээр дурдснаас гадна тус улсын олон арван хууль тогтоомжид заасан эрх мэдэл эдэлж, үүрэг гүйцэтгэнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг www.celnisprava.cz хэмээн веб хуудаснаас үзнэ үү.

БНЧУ-ЫН ГААЛИЙН ГАЗРААС ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙГ АМЬДРАЛД НЭВТРҮҮЛЭХ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тус улсын Гаалийн байгууллага нь эд зүйлсийг хуурамчаар үйлдэх, бусдын зохиолын хулгайлах зэрэг үйлдэлтэй тэмцэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог бөгөөд оюуны өмчийн эрх зөрчсөн сэжиг бүхий бараа бүтээгдэхүүнийг хурааж, тухайн эрх эзэмшигчдэд эрхээ хамгаалах бололцоо олгоно.

Гаалийн байгууллага нь оюуны өмчийн эрхийн зөрчлийг дараахь үйл ажиллагаанд илрүүлдэг. Үүнд,

- бараа бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвртүүлэх явцад,
- тус улсын дотоод зах зээлд тавигдах хяналтын хүрээнд (хэрэглэгчийг хамгаалах ажиллагаа).

Гаалийн байгууллага „Оюуны өмчийн зарим эрхийг зөрчсөн бараа бүтээгдэхүүн улсын хилээр оруулах, гаргах, дахин гаргахтай холбоотой арга хэмжээ болон өөр зарим хуульд нэмэлт өөрчлөлт оруулах“ тухай 191/1999 тоот хуулийн шинэчилсэн найруулгын дагуу дараахь эрх эдлэнэ. Үүнд,

а) оюуны өмчийн эрхийг зөрчсөн хэмээн үндэслэлтэй сэжиг бүхий бараа бүтээгдэхүүн саатуулах,

б) оюуны өмчийн эрхийг зөрчсөн бараа бүтээгдэхүүнийг устгах,

в) оюуны өмчийн эрхийг зөрчсөн хэмээн шүүхээр тогтоогдсон бараа бүтээгдэхүүнийг борлуулалт эсвэл өөр бусад төрлийн гүйлгээнээс татах,

г) дээр дурдсан хуулийн зөрчлийг захиргааны журмаар шийдвэрлэх.

Оюуны өмчийн эрхийг зөрчсөн бараа бүтээгдэхүүнтэй холбоотойгоор дараахь үйлдэл хийхийг хориглоно. Үүнд,

а) чөлөөт зах зээлд оруулах, улсын хилээр гаргах, гаалийн татвараас тэнсэн чөлөөлөхийг санаачлах,

б) улсын хилээр дахин гаргах, чөлөөт бус эсвэл чөлөөт агуулахад хадгалахыг санаачлах,

в) тухайн бараа гаалийн хяналтаас зайлсхийх магадлалтай байгаа бол Европын Холбооны гаалийн нутаг дэвсгэрт тээвэрлэн гаргах, БНЧУ-д өмчлөх, эзэмших, агуулахад хадгалах, борлуулах.

Гаалийн байгууллага „Хэрэглэгчийг хамгаалах“ тухай **634/1992** тоот хуулийн шинэчилсэн найруулгийг үндэслэн худалдаачдын бусдыг мэхлэн төөрүүлэх үйл ажиллагаа, хүмүүнлэгийн зориулалттай бараа бүтээгдэхүүнийг санал болгох, худалдах, улсын хилээр гаргах хорио цээрийн хяналт болон барааны зах ажилуулагч этгээдийн худалдагч нарын бүртгэл хөтлөх зэрэг үүргийн биелэлтэд хяналт тавих эрхтэй.

Үйчлүүлэгчдийг мэхлэн төөрүүлэх гэдэг бол оюуны өмчийн зарим эрхийн зөрчилтэй бараа бүтээгдэхүүнийг санал болгох, худалдах, цаашид борлуулах зорилгоор хадгалах, түүнчлэн бас худалдааны харилцаанд барааны таних тэмдэгийн тухай хууль зэргээр хамгаалагдсан лого, тэмдгийг хууль бусаар ашиглах гэж ойлгоно.

Оюуны өмчийн зарим эрхийн зөрчилтэй бараа бүтээгдэхүүнд эд барааны дараахь зүйл тооцно. Үүнд,

1. хулхи бараа – барааны тэмдгийн эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр өөрөөр хэлбэл барааны тэмдэгийн тухай 441/2003 тоот хуулийн шинэчилсэн найруулгын дагуу барааны тэмдгийн эзэмшигчийн эрхийг зөрчсөн тухайн барааны тэмдэгтэй ижил төстэй эсвэл андуурж болох таних тэмдэг бүхий бараа бүтээгдэхүүнийг сав баглаа боодлын хамт хулхи бараа гэж үзнэ. Үүнд уг бараанаас тусд нь тохиолдох барааны тэмдэг бүхий лого, шошго, стикер,

танилцуулга, ашиглах заавар, баталгааны баримт зэрэг зүйлээс гадна уг тэмдгээр тэмдэглэсэн сав баглаа боодол орно,

2. үл зөвшөөрөгдсөн дуурайдмал бараа – Уран зохиол, эрдэм шинжилгээ болон уран бүтээлийн зохиогчийн эрхийн тухай 35/1965 тоот хуулийн шинэчилсэн найруулгын зааснаар хуулбар үйлдэхийг хориглосон тохиолдолд зохиогчийн буюу түүнтэй ижил эрх эзэмшигч, бүтээгдэхүүний загварын эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хуулбарлан үйлдсэн бараа, бүтээгдэхүүн эсвэл дээрхи нөхцөлд үйлдсэн хуулбарыг агуулсан бараа бүтээгдэхүүн болно,

3. 527/1990 тоот хуулийн шинэчилсэн найруулгын дагуу патент, ашигтай загварын эрх эзэмшигч, эм бэлдмэл, урагмал хамгаалах бэлдмэлийн нэмэлт хамгааллын гэрчилгээ эзэмшигчийн эрхийг зөрчсөн бараа бүтээгдэхүүн,

4. Барааны гарал болон барааны гарлын газрын нэр хамгаалах болон хэрэглэгчдийг хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 452/2001 тоот хуулийн дагуу барааны гарал, барааны гарлын газрын нэрийг бүртгүүлсэн этгээдийн эрхийг зөрчсөн бараа бүтээгдэхүүн.

Гаалийн байгууллагаас явуулах хяналт шалгалт эхлэх шатандаа шалгагдах гэж буй этгээдэд шалгалт хийх тухайгаа мэдэгдэж, шалгалтын зорилго, учир шалтгааныг тайлбарлана. Хяналтын явцад юуны түрүүн бараа бүтээгдэхүүнийг санал болгох, худалдах, түүнчлэн бараа бүтээгдэхүүнийг санал болгох, борлуулах зорилгоор агуулахад хадгалах үйл ажиллагаанд үйлчлүүлэгчдийг мэхлэн төөрүүлэх шинж илрүүлэх буюу өөрөөр хэлбэл эдгээр тохиолдолд оюуны өмчийн эрхийн зөрчилтэй бараа бүтээгдэхүүн илрүүлэх чиглэлээр ажиллана.

- Гаалийн байцаагчид хяналт эхэлхээс өмнө өөрийгөө ямагт албан үнэмлэх эсвэл дүрэмт хувцасаар таниулж хяналт эхлэж байгааг мэдэгдэнэ. Гаалийн байцаагчдын дүрэмт хувцасны загварыг хавсралтаас үзнэ үү.
- БНЧУ-ын гаалийн байцаагчид шалгагдагч буй этгээдээс бараагаа хэрхэн олж авсныг гэрчилсэн баримт бичгийг шаардах эрхтэй.

Оюуны өмчийн эрхийн зөрчилтэй бараа бүтээгдэхүүн илрүүлсэн тохиолдолд гаалийн байцаагчид хууль тогтоомж зөрчсөн асуудлаар захиргааны ажиллагааг



үүсгэнэ. Торгууль оногдсон тохиолдолд тухайн зөрчилтэй бараа бүтээгдэхүүнийг тур саатуулах эсвэл хураах тухай шийдвэр гаргана.

Гаалийн байгууллагаас бараа бүтээгдэхүүнийг хураах тухай хүчин төгөлдөр бүхий шийдвэр гаргах эсвэл саатуулагдсан бараа бүтээгдэхүүн нь оюуны өмчийн эрхийн зөрчилгүй гэж тогтоогдвол түүнийг эзэнд нь буцаах тухай шийдвэр гаргах хүртэл саатуулна.

- Оюуны өмчийн эрхийг зөрчсөн этгээдэд Гаалийн байгууллагаас 634/1992 тоот хуулийн дагуу 5 сая хүртэл кроны торгууль ногдуулж, зөрчилтэй бараа бүтээгдэхүүнийг хураах эрхтэй.
- 191/1999 тоот хуульд зааснаар гаалийн байцаагчид оюуны өмчийн эрхийн зөрчилтэй байж болзошгүй барааг саатуулах, улмаар өмчийн эрхийн зөрчилтэй хэмээн шүүхийн шийдвэрээр тогтоогдсон тохиолдолд бараа бүтээгдэхүүнийг худалдаа болон бусад эргэлтээс татаж авах эрхтэй.
- Оюуны өмчийн эрхийг зөрчсөн этгээдэд Гаалийн байгууллагаас 191/1999 тоот хуулийн дагуу 20 5 сая хүртэл кроны торгууль ногдуулж, зөрчилтэй бараа бүтээгдэхүүн хураах эрхтэй.
- Гаалийн байгууллага хяналтын ажиллагааныхаа хүрээнд эзэн эсвэл зээмшигч нь зохиогчийн эрхийн тухай 121/2000 тоот хуулийн шинэчилсэн найруулгын дагуу зохиогчийн эрхийг зөрчсөн байж болох тохиолдолд CD, DVD зэрэг зөрчилтэй бараа бүтээгдэхүүнийг саатуулах эрхтэй.
- Гаалийн байгууллага гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй хэмээн үзсэн тохиолдолд Эрүүгийн 40/2009 тоот хуулийн шинэчилсэн найруулгын 268, 269, 270-р зүйлийн дагуу эрүүгийн хэрэг үүсгэнэ.



Хууль тогтоомжийн зөрчлийн талаарх ажиллагааны явцад худалдан авагчдыг мэхлэн төөрүүлсэн хэмээн хүчин төгөлдөр бүхий шийдвэр гарсан тохиолдолд зөрчилтэй бараа бүтээгдэхүүнийг санал болгож, худалдаж, хадгалж байсан этгээдэд гаалийн байгууллагад тухайн бараа саатуулах, тээвэрлэх, хадгалах зэргээс үүдэн гарсан зардлыг нөхөн төлүүлэх үүрэг хүлээлгэх бөгөөд төлбөр барагдуулах хугацаа шийдвэр хүргүүлсэн өдрөөс эхлэн 30 хоног байна.

ИНТЕРНЕТИЙН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ХЭЛТЭС

Тус улсын гаалийн байгууллага нь оюуны өмчийн эрхийг хамгаалах чиглэлээр явуулж буй ажиллагааныхаа хүрээнд Интернетийн гэмт хэрэгтэй тэмцэх тусгай хэлтэс байгуулсан юм. ИГХТХэлтэс нь интернетийн тогтмол ажиглалт, судалгаа хийх замаар оюуны өмчийн эрхийн зөрчилтэй бараа бүтээгдэхүүнтэй холбоо бүхий үйлдэл илрүүлхээр ажилладаг.

ХУВИАРАА БИЗНЕС ЭРХЛЭХ НӨХЦӨЛ БОЛЗОЛ

Бараа бүтээгдэхүүнийг зөвхөн дараахь нөхцлөөр санал болгож, борлуулж болно. Үүнд,

- 1) Хувиараа бизнес эрхлэх байр (үйлчилгээний газар /дэлгүүр) бизнес эрхлэхэд зориулалтын шаардлага хангасан, барилгын асуудал эрхлэх газраас зохих зөвшөөрөл авсан байна. Өөрөөр хэлбэл, байрны дэргэд үл зөвшөөрөгдсөн, хууль бусаар босгосон бүх байгууламж нураасан байх бөгөөд үл зөвшөөрөгдсөн барилга байгууламж нураагаагүй бол эдгээрийг албадан нураах арга хэмжээ авна.
- 2) Хувиараа бизнес эрхлэх байр (үйлчилгээний газар/дэлгүүр) нээх, хаах тухайгаа хувиараа бизнес эрхлэх асуудал эрхэлсэн газарт мэдэгдэнэ. Уг мэдэгдлийг үндэслэн үйлчилгээний газар/дэлгүүрийг албан ёсоор бүртгүүлнэ.
- 3) Хувиараа бизнес эрхлэх байр (дэлгүүр) бараа бүтээгдэхүүн худалдаалах зориулалттай бол зохих ёсоор буюу гадна талаас ил тод, үл арилах аргаар тэмдэглэсэн байна. Үүнд дараахь мэдээлэл агуулсан байна:
 - Аж ахуйн нэгжийн нэр эсвэл бизнес эрхлэгчийн овог нэр



- Улсын бүртгэл эсвэл регистрийн дугаар
- 2010.07.01-нээс хойш байгуулсан шйлдвэр/ дэлгүүрийн хувьд регистрийн дугаар
- Үйлдвэр/дэлгүүрийн хариуцлагатай ажилтны овог, нэр
- Үйлчлүүлэгчдийг хүлээн авах цагийн хуваарь

Шалгагдаж буй этгээд дэлгүүрт, үйлчилгээний газарт **чех эсвэл словак хэлний мэдлэгтэй хүнийг ажиллуулах шаардлага хангасан байна** – Хувиараа аж ахуй, бизнес эрхлэх тухай 455/1991 тоот хуулийн 31-р зүйлийн 8-р хэсгийг үзнэ үү.

ГАДААДЫН ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛД ТАВИХ ХЯНАЛТЫН ТУХАЙ

БНЧУ-ын гаалийн байгууллага нь доорхи хууль тогтоомжийг үндэслэн гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг хянах эрхтэй.

- БНЧех Улсын Гаалийн байгууллагын тухай 185/2004 тоот хуулийн шинэчилсэн найруулга,
- Улсын хяналт шалгалтын тухай 552/1991 тоот хуулийн шинэчилсэн найруулга,
- Хөдөлмөр эрхлэлтийн тухай 435/2004 тоот хуулийн шинэчилсэн найруулга.

Гаалийн байцаагчид ЕХ-ны гишүүн, гишүүн бус орны гадаадын иргэдийг шалгах эрхтэй.

Тус улсын гаалийн байцаагчид шалгагдаж буй этгээдээс дараахь зүйл шаардах эрхтэй. Үүнд,

- Паспорт, өөр төрлийн зорчих үнэмлэх зэрэг шалгагдаж буй этгээдийн биеийн байцаалт,
- Хөдөлмөрийн эрх зүйн харилцааг гэрчилсэн баримт, гэрээ,



- Хуулиар шаардсан тохиолдолд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл эсвэл ногоон карт,
- Тус улсад оршин суух зөвшөөрөл.

Гаалийн байцаагчид бичиг баримтаа шалгуулахаас татгалзсан этгээдийг Гаалийн тухай 13/1993 тоот хуулийн 30, 31, 32, 33-р зүйлийн дагуу 6 цаг хүртэл хугацаагаар саатуулж, дараа нь БНЧУ-ыг цагдаагийн байгууллагад шилжүүлнэ.

Шалгагдаж буй этгээд хүчин төгөлдөр бүхий хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл буюу ногоон картаа шалгуулж чадахгүй эсвэл шалгуулахаас татгалзсан бол гаалийн байцаагчид Гаалийн 13/1993 тоот хуулийн 30-р зүйлийн дагуу „Тайлбар өгсөн тухай тэмдэглэл“-ийг үйлдэнэ.

Шалгагдаж буй этгээд тус улсын албан ёсны хэл (чех хэл) мэдэхгүй тохиолдолд хянан шалгах ажиллагаанд орчуулагчдын жагсаалтад бүртгэлтэй орчуулагчийг **өөрийн зардлаар** оролцуулах эрхтэй.

Шалгалтын явцад гадаадын иргэд тус улсад оршин суух тухай хуулийн зөрчил илэрсэн тохиолдолд энэ тухайгаа тухайн газрын цагдаагийн хэлтэст мэдэгдэнэ.

Гаалийн байцаагчид гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг шалгаж байхдаа газар дээр нь торгууль эсвэл өөр ямар нэгэн төлбөр, хураамж ногдуулахгүй, өөрөөр хэлбэл **газар дээр нь бэлэн мөнгө авдаггүй**. Хөдөлмөр эрхлэлтийн тухай хуулийг зөрчсөн сэжиг илэрсэн тохиолдолд асуудлыг харъяагдах мужийн хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтын газарт шилжүүлнэ. Хяналт явуулж буй байцаагчдын хувьд ямар нэгэн эргэлзээ төрсөн, хяналт зохих бус аргаар явуулсан зэрэг тохиолдолд БНЧУ-ын гаалийн албаны авилгатай тэмцэх хэлтэсийн **+420 800 232 222** утсаар, **korupce@cs.mfcr.cz** хаягаар эсвэл БНЧУ-ын Цагдаагийн газрын **158** утсаар мэдэгдэнэ үү.

Хэрэв танд асуулт байвал тус улсын гаалийн байгууллагын аль ч хэлтэс эсвэл БНЧУ-ын Гаалийн байгууллагын зөвлөгөө, мэдээллийн төвд хандана уу. Утас: 261331919, цахим шуудан: informace@cs.mfcr.cz

